

## **Булган аймгийн Булган суманд хийсэн шалгалтын товч тайлан**

Шалгалтанд нийт 10 үйлчилгээ эрхлэгч хамрагдсанаас тусгай зөвшөөрлийн дагуу радио давтамжийг ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа нь телевизийн өргөн нэвтрүүлгийн 2, Утасгүй агаарын олон сувгийн телевизийн үйлчилгээ эрхлэх 2, радио өргөн нэвтрүүлгийн 3, ISP утасгүй интернэт үйлчилгээ үзүүлэгч 0 , нийт 7 тусгай зөвшөөрөл эзэмшигчид байсан. Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд үйл ажиллагаагаа явуулаагүй байсан болно.

### **Радио өргөн нэвтрүүлэг**

Нийт 5 аж ахуй нэгж, компаниуд байгаагаас үйл ажиллагаагаа явуулж буй 3 тусгай зөвшөөрөл эзэмшигч байлаа. Ауразон ХХК Радио ФМ-89.9 болон Сайхан Монгол Урсгал НҮТББ ФМ-107.1 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд үйл ажиллагаа хэвийн сайн явагдаж байлаа. Радио Телевизийн Сүлжээ УТҮГ ФМ-105.5-ын хувьд нэвтрүүлэх станцыг гаралтын чадал тусгай зөвшөөрөлд заасан үзүүлэлтээс бага байсан зэрэг дутагдлууд илэрсэн болно. Шинэ Монгол Долгион ХХК ФМ-104.5, Булган Энержи групп ФМ-107.5 эдгээр тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд үйл ажиллагаагаа явуулаагүй, техник тоног төхөөрөмж гэмтэж эвдэрсэн эсвэл үйл ажиллагаа явуулах техникийн нөхцөл бололцоо нь хангагдаагүй байлаа.

### **Телевизийн өргөн нэвтрүүлэг**

Булган Энержи группын Булган Ард телевиз, Сайхан Монгол Урсгал НҮТББ “Сайхан Монгол” телевиз, РТС УТҮГ Олон сувгийн телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид байлаа. Телевизийн 59-р сувгийн тусгай зөвшөөрөлтэй Ард телевиз нь радио давтамжийн спектрийн хувьд хажуугийн цацаргалт болон бусад зурвасд үүсгэж буй радио давтамжийн нөлөөлөл үгүй хэвийн байгаа боловч тусгай зөвшөөрөлд заагдсан чадал хүрэхгүй байгаа нь тогтоогдсон ба мөн нэвтрүүлэгчийн техникийн үзүүлэлт болон маркыг тусгай зөвшөөрөлд тусгах шаардлагатай болно. Сайхан Монгол Урсгал НҮТББ “Сайхан Монгол” телевиз нь тусгай зөвшөөрөлд заасан радио давтамж дээр үйл ажиллагааг явуулаагүй, мөн заасан чадлаас хэтрүүлсэн, телевизийн суваг дээр урсдаг зарыг ангилалын хамт нэвтрүүлэн үйл ажиллагааг явуулж байгаагаас гадна тус төрийн бус байгууллагад бүртгэлтэй ФМ-107.1-ийн нэвтрүүлгийг дуу нь “Сайхан Монгол” телевизийн сувгийн дуутай хамт зэрэгцэж явж байсан зэрэг зөрчил, дутагдлууд илэрсэн болно. РТС УТҮГ Олон сувгийн телевиз нь телевизийн 37, 39, 41, 43, 45, 47, 49, 51-р сувгийн модулятор дээр тохируулан 8 сувгаар телевизийн нэвтрүүлэг цацан, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байлаа.

### **Телевизийн олон сувгийг дамжуулах MMDS үйлчилгээ**

Сансар тур ХХК болон Мэдээлэл КаТВ ХХК-ийн хувьд Булган аймгийн Булган суманд хэмжилт шалгалтаар очих үед үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байсан болно.

### **Утасгүй интернэтийн WIFI-ийн хэмжилт**

Мобинет ХХК нь үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд тусгай зөвшөөрлийн хувьд хугацаа нь дууссан. БОЗУ ХХК нь утасгүй интернэтийн үйл ажиллагааг хэвийн явуулж байлаа.

### **Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдэд хийсэн хэмжилт**

Үүрэн холбооны Мобиком корпораци ХХК, Юнител групп ХХК, Скайтел ХХК, Жи-Мобайл ХХК оператор компаниудын тусгай зөвшөөрлийн радио давтамжуудад гадны харилцан нөлөөлөл илрээгүй бөгөөд давтамж ашиглалт хэвийн байв.